



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2013 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/697

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл балансаас
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 5.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн балансад бүртгэлтэй, нийт 113,870,037.60 (нэг зуун арван гурван сая найман зуун далан мянга гучин долоон төгрөг жаран мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Б.Батбилэг)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирж буй тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Д.Бат-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаярт)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



1110202934

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
06 сарын 06-ны өдрийн
11.5.07 захирамжийн
хавсралт



ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ

№	Эд хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Дахин үнэлсэн үнэ	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Тусгай зориулалтын автомашин	Мицубуши пусо	06-81 УБЯ	A00081	2003	113,870,037.60	113,870,037.60	0	41,746,249	Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс	Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс
	Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн					113,870,037.60	113,870,037.60	0	41,746,249		